

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
2023 оны 10 сарын 10 өдрийн
3/В албан бичгийн хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ
10 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	Тайлант хугацаанд манай байгууллагад 178026.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 163427.5 мянган төгрөгийг зарцуулж 14599.0 мянган төгрөг хэмнэсэн.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	9-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Санхүүгийн төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Хяналт шалгалтын үр дүн	10 сар	Санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт 14, төлөвлөгөөт бус 6 байгууллагад нийт 20 байгууллагад хийж 3.011.379,7 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 12.016,8 мянган төгрөгийг улсын төсвийн орлого болгуулахаар, 14.921,2 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7.100,2 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар нийт 33.486,0 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоосон. Үр дүн: Актын барагдуулалт 55 хувь.
3	Сүмбэр сумын орон нутаг хөгжлийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	10 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023.08 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтаар нийт 2,742.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 5.269,7 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоов. Акт барагдуулах хугацаа болоогүй

4	Талын илч ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	10 сар	Талын Илч ОНӨААТҮГ-т хийсэн дотоод аудитаар байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны түвшин 69.2 хувь нь 2-р түвшин буюу ДАВТАМЖТАЙ, түвшинд үнэлэгдсэн ба дотоод аудитаар илэрсэн 13 асуудал нь 7 нь нөлөө ихтэй буюу "Сайжруулах шаардлагатай" дүгнэлтийг өгч байна. Дотоод аудитаар илэрсэн 13 асуудалд цаашид сайжруулж анхаарах шаардлагатай 8, дутагдлыг арилгуулах 14 нийт 22 заалт бүхий хугацаатай зөвлөмжийг өгөв.
5	Баянтал сумын орон нутаг хөгжлийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	10 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Баянтал сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023.09 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 95 хувьтай үргэлжилж байна.
6	Боржигин чуулгын 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	10 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Дvv Бvжгийн Боржигин чуулгын 2022-2023.07 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн. Дотоод аудитаар тус байгууллагад "Дунд" эрсдэлтэй буюу "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгөв. Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үнэлэв. Аудитаар илэрсэн 13 асуудал буюу 69.2% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн бөгөөд шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд 18 заалт бүхий хугацаатай зөвлөмж өгсөн.
7	Аймгийн ЗДТГазрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	10 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн ЗДТГазрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 95 хувьтай.

8	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах	10 сар	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 9 дүгээр сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдалд хяналт шалгалт хийсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 93 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 4.7 хувиар буурчээ.
9	Шивээговь сумын орон нутаг хөгжлийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	10 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023.08 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 60 хувьтай үргэлжилж байна.
10	Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах	Хамтын ажиллагаа сайжирна.	10 сар	Аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран А.Ундармаагийн 2017 оноос хойшхи авсан цалин хөлс дээр Мэргэшсэн нягтлан бодогч Э.Цэлмэгбаярыг шинжээчээр ажиллуулсан.
11	Шивээговь сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	10 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 30 хувьтай үргэлжилж байна.
12	Баянтал сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	10 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Баянтал сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 20 хувьтай үргэлжилж байна.
13	Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	10 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 10 хувьтай үргэлжилж байна.
14	Сум дундын ойн ангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	10 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сум дундын ойн ангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 15 хувьтай үргэлжилж байна.


15	Сүмбэр сумын лаборатори 5 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	10 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын лаборатори 5 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна. Шалгалтын явц 30 хувьтай байна.
16	Баянтал сумын Засаг даргын тамгын газар	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	10 сар	Баянтал сумын ЗДТГ-ын хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бүс дотоод аудит хийлээ. Дотоод аудитаар байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны түвшин 50 хувь нь 2-р түвшин буюу ДАВТАМЖТАЙ, үнэлэгдсэн ба дотоод аудитаар илэрсэн 12 асуудлаас 10 нь нөлөө ихтэй буюу "Сайжруулах шаардлагатай" дүгнэлтийг өгч байна. Дотоод аудитаар илэрсэн 12 асуудлын 83 хувь нь удирдан зохион байгуулалт муу байгаагаас үүссэн байна. Иймд цаашид сайжруулж анхаарах шаардлагатай 13, дутагдлыг арилгуулах 30 нийт 43 заалт бүхий хугацаатай зөвлөмжийг өгөв.
17	Илчлэг шивээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	10 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын лаборатори 5 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна. Шалгалтын явц 95 хувьтай байна.
18	Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	10 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна. Шалгалтын явц 40 хувьтай байна.
19	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	10 сар	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 6 мэдээ байршуулсан. Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд мэдээлсэн.
20	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.		Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 4 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.

			10 сар.	Ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж байгаа "Авлига миний эргэн тойронд", "Авлигыг таслан зогсооход миний хувь нэмэр" сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг 10 дугаар сарын 4-17-ны өдрүүд зохион байгууллаа. Уралдаанд нийт 6 бүтээл ирүүлсэн байна. 10 дугаар сарын 10-ны өдөр "Эрсдэлд суурилсан аудит хийх нь", "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах тухай" сэдвээр Шивээговь сумын төрийн байгууллагын удирдлага, дотоод хяналтын болон санхүүгийн ажилтан албан хаагч нарт зориулсан сургалт зохион байгуулагдлаа. Сургалтад нийт 14 албан хаагч хамрагдлаа. 10 дугаар сарын 11-ны өдөр Сонгуулийн Ерөнхий Хорооноос орон нутагт зохион байгуулж буй сургалтад Говьсүмбэр Санхүүгийн Хяналт дотоод аудитын алоан хаагчид хамрагдаж байна. 10 дугаар сарын 12-ны өдөр Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны албан хаагчид "Дахивар авах өдөрлөг"-т очиж хуримтлуулсан цаасаа тушаалаа. 10 дугаар сарын 16-ны өдөр ЦХХХЯ-аас зохион байгуулж буй "Цахим ур чадвар олгох" сургалтад Санхүүгийн хяналт, дотоод аудитын албан хаагчид хамрагдлаа. 10 дугаар сарын 18-ны өдөр "Эрсдэлд суурилсан дотоод аудит хийх нь", "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах тухай" сэдвээр Сүмбэр сумын ЗДТГазар, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГазар, 1, 2, 5-р сургууль, 1, 2, 5, 6-р цэцэрлэгийн удирдлага, дотоод хяналтын болон санхүүгийн ажилтан нарт зориулж сургалт амжилттай зохион байгууллаа. Сургалтад нийт 27 ажилтан албан хаагч оролцлоо. 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Швейцарийн хөгжлийн агентлага, Удирдлагын академи, аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж буй "Гүнгийн удирдлагын байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах" сургалтад Санхүүгийн хяналт, дотоод
--	--	--	---------	---

				аудитын албан хаагчид идэвхитэй хамрагдлаа 10 дугаар сарын 23-ны өдөр “Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл”, “Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо” Аймаг, сумдын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл”, “Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо”-ны гишүүдийг чадавхижуулах сургалтад СХДАА-ны дарга Н.Алтанцэцэг хамрагдсан. Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Сум дундын Ойн ангийн ойн зурвас газарт X/17 нд намрын мод тариалалт хийсэн. Мөн хувиарлагдсан 2014 оны талбайд мод арчилгаа, усалгааг X/24 хуваарьт өдөр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Мод бүрийн тогоог дахин засаж, тогоолж, усалгааны үйл ажиллагааны бэлтгэл хангасан. 2. Орчны хог хаягдлыг цэвэрлэж хогийг хогийн цэгт хаясан. 3. Нөхөн тарилт үрээр хийсэн.
--	--	--	--	--

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:



Л.Эрдэнэчимэг